

**“Монгол улс дахь хөрөнгө оруулалт” 3-р Чуулга Уулзалтанд Оюу Толгой ХХК-ийн
Гүйцэтгэх Ерөнхий Захирал бөгөөд Ерөнхийлөгч Камерон МакРейн тавьсан илтгэл,
2012 оны 10-р сарын 30**

“Монгол улс дахь хөрөнгө оруулалт” гуравдугаар чуулга уулзалтанд Оюу Толгой болон Рио Тинто компаниудыг төлөөлөн өнөөдөр үг хэлж байгаадаа баяртай байна.

Оюу Толгой Төсөл болон Монгол улсын ирээдүйн хөгжлийн хувьд чухал цаг үе тулж ирээд байгаа билээ. Оюу Толгой төсөл анхны зэсийн баяжмалаа 2013 онд гаргахаар ажиллаж байна. Өнөөдөр би үүнтэй холбоотой хүлээлт болон энэ хүлээлтийг биелүүлэхийн тулд юуг зайлшгүй хийх шаардлагатай талаар ярья.

2001 онд Оюу Толгой ордыг олсноос хойш олон зүйл болж өнгөрсөн.

Дэд бүтэц байхгүй говь цөл газар бид 2010 оноос эхлэн уурхайг барьж эхэлсэн. Хоёр жил хагасын дараа дэлхийн хэмжээний уурхайг ашиглахад бэлэн болоод байна. Эдгээр зургуудыг энэ 7-р сард авсан бөгөөд ил уурхайгаас олборлосон хүдрийг анхдагч бутлуураар дамжуулан хүдрийн агуулах руу зөөж байгааг харуулж байна. Оюу Толгойн ил уурхай үйл ажиллагаагаа эхлээд байна. Баяжуулах үйлдвэрийг барьж дуусгаад одоо ашиглахад бэлэн болоод байна. Оюу Толгой уурхай ирээдүйд дэлхийн хэмжээний 5 том зэсийн уурхайн нэг болж, Ази тивд олборлосон зэсийн 24 хувийг нийлүүлнэ. Энэ нь Оюу Толгой уурхай Монгол улсын ирээдүйд дорвитой хөгжлийг авчрах боломжийг бүрдүүлж байна.

Рио Тинто болон Turquoise Hill компаниуд нь Оюу Толгой төслөөс өмнө боломжгүй байсан асар их хэмжээний хөрөнгө оруулалтыг Монгол улсад татсан билээ. Энэ хөрөнгө оруулалт нь үр ашгаа тэр даруйдаа бодитой өгч эхэлсэн билээ. Үүнд би Монгол улсын Засгийн газарт татвар, зээл болон бусад төлбөрийн хэлбэрээр өгөөд байгаа 800 гаруй сая ам.долларыг зөвхөн хэлээгүй билээ.

Бид ил уурхай, бутлуур, түүзан дамжуулагч бүхий хамгийн орчин үеийн баяжуулах үйлдвэрийг барьж Оюу Толгой уурхайг барьж байгуулаад байна. Мөн бид Засгийн газрын болон бусдын санхүүгийн тусламжгүйгээр 220 КВ-ын цахилгаан эрчим хүчний дэд бүтэц, 3.2 км-ын урттай нисэх талбай бүхий олон улсын стандартын нисэх буудал, 100 км засмал зам зэргийг шинээр барьж байгуулав. Эдгээр нь Өмнийн Говьд дэлхийн хэмжээний бизнесийн үйл ажиллагаа, орон нутгийн хөгжил цэцэглэлд чухал шаардлагатай билээ. Үзэгдэж харагдахгүй хэдий ч, хамгийн чухал нь болох хүний нөөцийн чадавхийг бид бий болгосон. Тавьсан зорилтынхоо хүрээнд бид Монгол улсад дэлхийн хэмжээний ажиллах хүчийг сургаж, хөгжүүлэхэд зориулж 126 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийж байна. Эдгээр ажиллах хүч нь Оюу Толгой компаний бүхий л түвшинд ажиллах боломжтой юм. Энэ нь олон жил шаардлагатай ихээхэн том зорилт бөгөөд манай үйл ажиллагаанд болон Монгол улсад нэн шаардлагатай, зөв зүйл гэдэгт эргэлзэхгүй байна. Мэргэжлийн сургуулийг барьж, байгуулан, орчин үеийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, 1200 гаруй мэргэжлийн сургалтын багш нарыг бэлтгэж байна. Үүнд манай өөрийн компанийн ажилчдад зориулсан сургалт болон манлайлалын хөтөлбөрийг оруулаагүй байгаа болно.

Хүний нөөцөөс гадна, бид бизнесийн чадавхийг бэхжүүлж байна. Манай компанийн дотоодын ханган нийлүүлэлтийн хөтөлбөрийн хүрээнд Монголын ханган нийлүүлэгчдээс бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад олон зуун сая ам.долларыг зарцуулаад байна. Бид Монголын томоохон компаниас эхлэн бичил-санхүүжилт болон дөнгөж эхэлж буй бизнесүүдэд зориулсан бизнес эрхлэх үр чадвар зэргээр Монголын компаниудад өсөж хөгжихөд нь зориулж шууд хөрөнгө оруулалт хийж байна. Эдгээр бүх зорилтыг бид бодитойгоор хэрэгжүүлээд байгаа билээ.

2013 онд үйлдвэрлэлээ эхлээд цаашид бид яах вэ? Үүнд Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын хамгийн чухал үнэ цэнтэй үр дүн удахгүй гарч эхэлнэ гэж хариулмаар байна. Өнөөдрийг хүртэл бид дэлхийн хэмжээний уурхайг барьж байгуулахад хөрөнгө оруулалт хийсэн.

Эхний хөрөнгө оруулалт эрэл хайгуулын үе шатанд зарцуулсан нэг тэрбум доллар байсан бөгөөд энэ нь барилгын ажлын өмнөх үе шат юм.

Энэ хугацаанд бид Оюу Толгойн бүтээн байгуулалтын ажлыг эхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах талаар Монгол улсын Засгийн газартай хэлэлцээр хийж эхэлсэн. Энэ хөрөнгө оруулалтын гэрээ Оюу Толгойн бүтээн байгуулалтын ажлыг эхлэхэд нэн шаардлагатай байсан. Оюу Толгой уурхайг барьж байгуулахад олон тэрбум долларын хөрөнгө оруулалт болон олон жил шаардлагатай гэдгийг хөрөнгө оруулагчид мэдэж байлаа. Бүх хамтрагч талуудыг энэ үйл явцад оролцуулах баталгаа өгөхөөс нааш хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийхийг хүсэхгүй байлаа.

Хөрөнгө Оруулалтын Гэрээг байгуулсны дараа бид уурхайг богино хугацаанд барьж байгуулсан.Одоо Оюу Толгойн ил уурхай ажиллаж байгаа бөгөөд баяжуулах үйлдвэр ажиллахад бэлэн болоод байна.

Энэ бол дэлхийн хэмжээний бизнес үйл ажиллагааны суурь үндэс юм. Гэхдээ Оюу Толгойн баялгийн 80 хувь нь ил уурхайд биш, харин далд уурхайн гүнд байгаа билээ. Энэ нь манай бүтээн байгуулалтын ажлын дараагийн үе шат бөгөөд үүнийг олон улсын эх үүсвэрээс санхүүжүүлэх шаардлагатай байгаа билээ.

Энэ хөрөнгө оруулалт нь дэлхийн хамгийн том бөгөөд хамгийн гүнзгий гүнийн уурхайн байгууламжийг барьж байгуулах юм. Тус уурхайгаас ихээхэн өндөр агуулгатай хүдрийг өндөр бүтээмжтэйгээр олборлох юм. Оюу Толгойн жинхэнэ баялгийг нээхийн тулд олон жилийн бүтээн байгуулалтын ажлыг хийх шаардлагатай байгаа билээ.

Одоо бид Засгийн газрын түншүүдээсээ тэдний амлалт, хүлээсэн үүрэг хэвээрээ байна гэсэн баталгааг авахыг зорьж байна. Бидний хамтын ажиллагааны талаар Оюу Толгойн Хөрөнгө Оруулалтын Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэж , биелүүлэх нь дараачийн шатны бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд шаардлагатай билээ.

Уул уурхайн салбарт ажилладаггүй хүмүүсийн хувьд ийм олон жил, ийм их хөрөнгө зарцуулах шаардлагатай юм уу гэж асууж болох юм. Ашигт малтмалын түүхий эдийн эрэлт хэрэгцээний талаар бид байнга сонсож байдаг. Сүүлийн саруудад зарим нэг ашигт малтмалын түүхий эдийн эрэлт хэрэгцээ савлагаа ихтэй байгаа билээ. Гэхдээ

зэсийн эрэлт хэрэгцээ их байгаа бөгөөд энэ хэвээрээ байх төлөвтэй байна. Хятад улсын хотжих үйл явц зэс их хэрэглэдэг дэд бүтцэд ихээхэн хөрөнгө оруулалт хийх шаардлагыг бий болгож байна. Арван хоёр жилийн дараа Хятадын зэсийн хэрэглээ өнөөдөртэй харьцуулахад 10 сая тонноор өсөх төлөвтэй байна.

Оюу Толгой уурхайн эхний гурван жил гаргах баяжмалын 75 хувийг Рио Тинто компанийн маркетингийн алба олон улсын зах зээлийн үнээр Хятадын зэс хайлуулах үйлдвэрүүдэд борлуулах гэрээг хийж чадсан нь Рио Тинто компанийн хувьд бахархах зүйл болж байгаа бөгөөд Монгол улсын хувьд ч ихээхэн том амжилт юм. Энэ нь туршлагатай уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа улс орныхоо ашигт малтмалын үнэ цэнийг хэрхэн хамгийн өндөр байлгаж чаддагийг харуулж байна. Энэ нь үйлдвэрлэл эхлэхээс ч өмнө бидний биелүүлж чадсан “**хамтын ажиллагааны үнэ цэнийн**” талаарх зорилт юм.

Хятад болон Монгол улсын хоорондын хоёр талын худалдааны харилцааг хөгжүүлэх нь хоёр улсын эдийн засгийн амжилтанд нэн шаардлагатай юм. Монгол улс Хятад болон Орос улсын хооронд байрладаг газарзүйн байршлаа давуу тал болон сул тал гэж харж болох юм. Миний хувьд Монгол улс Хятадын эдийн засгийн хөгжил болон худалдаанаас **ихээхэн ашиг олох төгс байршилтай** гэж боддог.

Маркетингийн давуу талаас гадна Монгол улсын хувьд ихээхэн чухал энэ том хэмжээний төсөлд Рио Тинто яаж оролцож байгаа вэ?

Нэгдүгээрт, бид бизнесийн бүхий л үйл ажиллагаагаа хамгийн өндөр стандартын дагуу хийдэг. Аюулгүй ажиллагаа бол зөвхөн эхлэл бөгөөд бид байгаль орчин, үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтайгаа харилцах харилцаа, бизнесийн үйл ажиллагааны стандартыг хамгийн өндөр төвшинд авч үзэн үйл ажиллагаагаа явуулдаг.

Бизнесийн үйл ажиллагааны эдгээр стандартын дагуу бид үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд мөн эдгээр нь Монгол улсад бүхэл бүтэн ханган нийлүүлэгчдийн бааз суурийг бий болгоход эерэгээр нөлөөлж байна.

Дээрх стандартаас гадна, бид уул уурхайн шилдэг тэргүүний туршлага болон технологийг нэвтрүүлж байгаа болно. Блокчлон олборлох талаар бидний мэдлэг туршлага, гүнийн уурхайгаас олборлолт явуулах үр дүнтэй, зардал багатай, аюулгүй үйл ажиллагааны тулгуур суурь болно. Рио Тинто компани нь блокчлон олборлох чиглэлийн дэлхийн хэмжээний тэргүүлэгч компани бөгөөд дэлхийд блокчлон олборлох аргаар үйл ажиллагаа явуулж байгаа 16 уурхайн 7 уурхайг ажиллуулж байгаа билээ. Бид энэ технологийг Монгол улсад нэвтрүүлж байгаадаа их бахархаж байна.

Бид мөн эдийн засгийн ашиг тусын талаарх яриа хэлэлцүүлэгт шударгаар оролцогч гэж өөрсдийгөө үздэг. Манайхтай адил төсөл **эдийн засгийн бодит үр ашгийг** бий болгодог нь ихээхэн чухал зүйл юм. Бид мөн өөр бусад олон төслийн боломжийн талаар ихээхэн итгэл найдвар тавьж байгаа билээ. Монгол улсын хөгжил цэцэглэл та бүхний хөрөнгө оруулалтаас хамаарна. Монгол улсад таны хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа билээ. Таны төсөл Монгол улсад хэрэгтэй. Эдгээр төслийг хөгжүүлэх, дагалдах эдийн засгийн ашиг тусыг бий болгохын тулд хөрөнгө оруулалтын

таатай орчныг бий болгох бодлого журмыг боловсруулж дуусгана гэдэгт би итгэж байна.

Энэ зуун жилийн хугацаанд Монгол улсын өсөлт хөгжилтөнд Оюу Толгой тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ гэдэгт би бүрэн итгэлтэй байна. Гэхдээ энэ уурхайн нөөц боломжийг бүрэн ашиглахын тулд энэ хөрөнгө оруулалтыг бий болгосон тогтвортой байдлыг хадгалах шаардлагатай билээ.

Монгол улсад шинэчлэлийн асуудлыг эн тэргүүнд авч үзсэн парламентийг саяхан сонгосон билээ. Хэд хэдэн чухал хуулиуд шийдэгдээгүй болон тодорхойгүй байгаа билээ.

Одоогийн байдлаар Монгол улсын хувьд хөгжлийн янз бүрийн шатанд байгаа хэд хэдэн төслүүд байгаа бөгөөд эдгээр төсөл нь эрэл хайгуулын шатнаас бүтээн байгуулалтын өмнөх шатны ТЭЗҮ-ийн судалгааны шатандаа явж байгаа билээ. Оюу Толгой төсөл Монгол улсын хувьд ихээхэн өөрчлөлт авчирсантай адилхан, эдгээр төслүүд эдийн засгийн ихээхэн өөрчлөлтийг авчрах боломжтой юм.

2009 онд Оюу Толгойн Хөрөнгө Оруулалтын Гэрээнд гарын үсэг зурснаас хойш Монгол улсын эдийн засгийн 25 хувийг Оюу Толгой бүрдүүлжээ. Тиймээс, бид улс төрчдийн анхаарлыг ихээр татах болсон. Ийнхүү анхааралд орсноос өнгөрсөн гурван жилийн хугацаанд **Монгол улсын эдийн засгийн амжилтыг** бүрдүүлсэн **Оюу Толгойн Хөрөнгө Оруулалтын Гэрээнд эргэлзсэн** зүйлүүд гарч байгаа билээ.

Энэ хөрөнгө оруулалтын гэрээ Монгол улсын өсөлт хөгжлийн мөчлөгийг эхлүүлсэн хэдий ч зарим хүмүүс төслийн илүү их ашгийг Монголд шилжүүлэхийн тулд гэрээг өөрчилж, дахин хэлэлцээр хийх шаардлагатай гэж үзэж байна. Энэ үзэл бодлын хувьд Монгол улсад тулгарч байгаа асуудал гэвэл шинэ төслийг эхлүүлэх бодолтой хүмүүс Оюу Толгойн хөрөнгө оруулагчидтай хэрхэн харьцаж байгааг анхааралтай ажиглаж байгаа билээ. Хууль эрзүйн хувьд тодорхойгүй байгаа Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалт, уул уурхайн хууль, татвар зэргийг тэд бас харж байгаа.

Өөрөөр хэлбэл, Монгол улстай холбоотой дараахь хоёр ерөнхий хүрээний асуудалд хөрөнгө оруулагчид ихээхэн анхаарал тавьж байна гэж би харж байна.Үүнд:

Нэгдүгээрт, бид 2012 болон 2013 оны засгийн газрын төсөвт тулгарч байгаа асуудлыг ойлгож байна. Богино хугацааны эдийн засгийн төлөв байдал Засгийн газрын хувьд бэрхшээлтэй байгаа билээ.

Хоёрдугаарт, амлалт болон гэрээг өөрчлөхгүй болон өөрчлөж болох тухай зэрэг ярьж байгаа **улс төрийн популист үзэл бодлыг** бид сонсож байгаа билээ. Энэ нь хөрөнгө оруулагчид болон санхүүжүүлэгчдийн хувьд тодорхойгүй байдлыг бий болгож байна.

Саяхан Засгийн газрын зүгээс Оюу Толгойн Хөрөнгө Оруулалтын Гэрээг өөрчлөх хэлэлцээрийг хийхээр хүсэлт ирүүлсэн. Рио Тинто компани татгалзсан хариу өгсөн. Үүнээс хойш, Засгийн газар гэрээг хүчингүй болгохыг зориогүй бөгөөд зарим нэг өөрчлөлт хийхийг л хүсэж байна гэж мэдэгдэх болсон. Энэ гэрээ бол Оюу Толгой

төслийн суурь үндэслэл бөгөөд **өөрчлөх ёсгүй** гэж бид байнга үзэж ирсэн бөгөөд үүнийгээ саяхан бас илэрхийлсэн. Оюу Толгойн Хөрөнгө Оруулалтын Гэрээ бүх талуудын үүрэг хариуцлага болон хүртэх ашиг тусыг тэнцвэртэйгээр тусгасан гэдэгт бид чин сэтгэлээсээ итгэдэг билээ.

Монгол улсын хамгийн том компани болохын хувьд улсын хэмжээний асуудлуудын талаар бүтээлчээр харилцан ярилцаж байх ёстой гэдэгт бид итгэдэг. Монгол улсын эдийн засгийн өсөлт хөгжил цаашдаа үргэлжлэн, тогтвортой байх нь Монгол улсын Засгийн газар болон олон улсын хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн чухал асуудал билээ. Бид бүгдээрээ Монгол улсын эдийн засгийг өсөн хөгжиж, төрөлжиж, бүх Монголчуудын хувьд хүртээмжтэй хөгжил цэцэглэлийг бий болгохийг хүсэж, зорьж байгаа билээ.

Бид Монгол улсын Засгийн газарт Оюу Толгой төслийн бизнесийн талаар харилцан ярилцах бүхий л боломжийг ашиглах хүсэл эрмэлзэлтэй байгаа гэдгээ илэрхийлсэн билээ.

Засгийн газар одоо тулгарч байгаа төсвийн асуудлаа шийдэхийн тулд олон улсын санхүүжүүлэгчид болон хөрөнгө оруулагчдын туслалцааг хүлээн авна гэдэгт бид итгэж байна. Гэсэн хэдий ч Засгийн газрын өөрийн статистик баримтаас харахад гадаадын шууд хөрөнгө оруулалт одоогийн байдлаар буурч байна. Энэ туслалцааг өгөхийн тулд олон улсын хөрөнгө оруулагчид Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчдад амласан амлалтаа биелүүлнэ гэдэг баталгааг дахин хүсч байгаа нь харагдаж байгаа билээ.

Монгол улс өөрийн амлалтаа биелүүлнэ гэдэгт би одоо итгэлтэй байна. Энэ төсөл бол зорилтоо биелүүлж, хэрэгжүүлдэг, амжилтанд хүрэх төсөл билээ. Засгийн газар болон бизнесийн хоорондын түншлэл хэрэгжиж байгаа бөгөөд аль аль тал нь хамгийн сайн хийж чаддаг зүйлдээ илүү төвлөрч ажилласан тохиолдолд амжилтанд хүрэх нь зайлшгүй билээ.

Рио Тинто, Оюу Толгой болон манай хөрөнгө оруулагчид, удирдлага болон ажилтнууд, олон улсын болон дотоодын ханган нийлүүлэгчид зэс бизнесийн үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн байна. Энэ бол бидний хамгийн сайн хийж чаддаг зүйл юм.

Засгийн газрын хувьд, Петрочайна компанийн бүтээгдэхүүн хуваах гэрээний талаар Уул уурхайн сайд Ганхуягийн хэлсэн тайлбарт бид ихээхэн урамшсан билээ. Тэр энэ гэрээг нэг талын санаачилгаар өөрчлөхгүй гэдгийг тодорхой хэлсэн.

Бид болон бизнесийн салбарынхан цаашдын баталгааг хүлээж байгаа билээ. Энэ үндсэн дээр Оюу Толгой төслийн ашиг тусыг Монголчуудад болон хөрөнгө оруулагчдадаа бүрэн хүртээх үйл ажиллагаагаа итгэл найдвартайгаар үргэлжлүүлнэ.